



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 32 25, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@ama.gov.mn,
Цахим хуудас: www.ama.gov.mn

2024.10.10 № 01/1752
танай _____ -ны № _____ -т

Г Тендерийн баримт бичиг
хянасан тухай

Танай газраас зарласан “Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Хөвсгөл/” ХӨАХААГ/20240102163 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдол “Шидэт гол” ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.1-д “Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 оны борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална” гэж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн ТШЗ 18.1-д “Борлуулалтын орлогын хэмжээ нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн [тоо бичих] хувиас багагүй байх.” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.1-д “... борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх” гэж боловсруулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д “Тендерт оролцогч нь 2021, 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд захиалагч Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.

0000323

Жич: “2021, 2022, 2023 оны санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайланг e-balance цахим бүртгэлд шивээгүй, баталгаажуулаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална” гэж, 16 дугаар зүйлийн 16.2.2-т “сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан” гэж, 16.2.3-т “сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл” гэж, 16.4-т “Хуулийн дагуу санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчоос санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шаардаж болно” гэж, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн ТШЗ 19.1-д “Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1-д заасан шалгуур үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу боловсруулсан байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.1-д холбогдох өөрчлөлт оруулан, хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг захиалагчид даалгаж байна.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

ХМТ 2023.09.07
УНЧИН
10.09.2023
16:15
ДАРГА